



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“Евразия капитал холдинг ҮЦК” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4-р сарын 30-ны өдөр 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпийн гудамж, Реженси Резиденс байр 3-р давхарт 314 тоот өрөөнд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Энэхүү хуралд компанийн хувьцаа эзэмшигчид болох иргэн Г.Оюунболд, “Мезза Файнэншл Групп” ХХК, “Омега Инвест” ХХК, “Вистекс Глобал Инвест” ХХК нар оролцсон бөгөөд нийт 2 224 776 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 2 270 892 ширхэг энгийн хувьцааны 98% болж хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хурлын дарга Г.Оюунболд:

- Хурлыг онлайнаар нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийг өөрчлөн байгуулах
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах
5. Бусад.

Хурлаар хэлэлцэх асуудлаа нэг бүрчлэн авч хэлэлцээд тухай бүрд нь асууж тодруулах зүйлээ асууя гэсэн саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна.

Хурлын дарга Г.Оюунболд:

- “Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – гийн талаар компанийн Гүйцэтгэх захирал Г.Оюунболд миний бие танилцуулъя. Мөн ТУЗ-ийн дүгнэлт ч та бүхэнд танилцуулагдах болно.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тус компани нь 2019 онд гурван мянга гаруй данс шинээр нээж, хөрөнгө оруулалтын зөвлөхийн ажлыг эрчимжүүлж ажиллаа.

1. Санхүү байдлын тайлан

- 2019 оны жилийн эцэст эргэлтийн хөрөнгө 2,699,743.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаснаас Мөнгөн хөрөнгө 2,068.1 мянган төгрөг, Дансны авлага 439,827.6 мянган

төгрөг, Бараа материал 1,930.4 мянган төгрөг, бусад санхүүгийн хөрөнгө 2,255,572.8 мянган төгрөг тус тус байна.

- Харин эргэлтийн бус хөрөнгө буюу үндсэн хөрөнгийн хувьд 24,039.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
- Богино хугацаат өр төлбөр 823,685.0 мянган төгрөг, Урт хугацаат өр төлбөр 714,131.9 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй тайлагнасан байна. Богино хугацаат өр төлбөр нь цалингийн өглөг, дансны өглөг, НДШ болон татварын өглөг, бусад богино хугацаат өр төлбөрөөс бүрдэж байна. Урт хугацаат өр төлбөр нь Толгой компанийн хоорондын тооцооны үлдэгдэл байна.
- Эздийн өмчид тайлант хугацаанд өөрчлөлт гараагүй байна.

2. Орлогын дэлгэрэнгүй тайлан

- Тайлант хугацаанд нийт 47,233.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого, үйл ажиллагааны орлоготой холбогдуулан гарсан өртөг 38,983.4 мянган төгрөг, үйл ажиллагааны зардлын ерөнхий удирдлагын зардал 97,024.4 мянган төгрөг, бусад зардал 4,338.9 мянган төгрөгийн зардал тус тус гарч тайлант хугацаанд 93,091.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3. Өмчийн өөрчлөлтийн тайлан

- Тайлант хугацаанд өмчид өөрчлөлт гараагүй байна.

4. Мөнгөн гүйлгээний тайлан

- Мөнгөн гүйлгээний тайлан нь тайлант хугацаанд мөнгөөр гарсан ажил гүйлгээ тусгадаг. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой мөнгөн орлого 47,233.2 мянган төгрөг, мөнгөн зарлага 67,178.6 мянган төгрөг;
- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага нь бусдад олгосон 19,906.0 мянган төгрөг байгаа;
- Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогод 77,172.7 мянган төгрөгийн зээл, үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө, зарлага нь төлбөрт төлсөн 44,781.4 мянган төгрөг байна.

Санхүүгийн тайланг шинжлэхэд:

✚ Төлбөрийн чадварын шинжилгээ

Нийт эргэлтийн хөрөнгөөс Богино хугацаат өр төлбөрийг хасаад Цэвэр эргэлтийн хөрөнгийн үзүүлэлт гарч ирдэг:

Эргэлтийн хөрөнгө	2,699,743.8 мянган төг
Богино хугацаат өр төлбөр	823,685.0 мянган төг
Цэвэр эргэлтийн хөрөнгө	<u>1,876,058.8</u> мянган төг

✚ Өр төлбөрийн хувийн жин

Нийт өр төлбөрийн нийт хөрөнгөд харьцуулдаг. Тайлант жилийн эцсийн үзүүлэлтээр нийт өр төлбөр нь нийт хөрөнгийн 56.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 2.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Манай хөрөнгө оруулагчид, сангууд Монголоос гарсан хэдий ч бид харилцигчдаа хохироохгүйн үүднээс үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулж байна. Энэ богино хугацаанд харилцагчдыг шилжүүлэх ажил удааширч магадгүй гэж бодсон.

1072 хувьцааны ногдол ашиг хувиарлахаар шийдвэрлэсэнээс улбаалан харилцагчид дансны мэдээлэлээ асуух, солих зүйл ажил их хийгдэж байна.

Бид нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааныхаа төвлөрлийг бууруулах, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, BNY Mellon банкттай хамтран хадгаламжийн бичиг /Depository receipt/-ийг нэвтрүүлэх, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ хэрэгжүүлэх, өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй /Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэлгээний газраас нэгж хувьцааны үнийг 540 төгрөгөөр тогтоосон/ 200 000 000 /хоёр зуун сая/ ширхэг хувьцаа нэмж гаргахаар 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн гэдгийг та бүхэн маань мэдэж байгаа байхаа.

Бид татан төвлөрүүлэхээр төлөвлөөд зөвшөөрлөө авсан байсан таван тэрбум төгрөгийг гадны хөрөнгө оруулагч нараас татан төвлөрүүлэх бүрэн боломж 2017 онд байсан. Санхүүгийн Зохицуулах Хорооноос хариу шийд өгөхгүй байсаар манай хөрөнгө оруулагч нар Монголоос гарч бидэнд ихээхэн хохирол учирсанг та бүхэн мэдэж байгаа. Хэрвээ тэр мөнгийг татан төвлөрүүлсэн байсан бол бид өнгөрсөн жил хувьцааны арилжаанд маш сайн оролцох цаашлаад манай ашиг орлого ч сайн байх байлаа.

Мөн бид шинээр IPO-нд амжилттай оролцох бүрэн боломж байсан. Санхүүгийн Зохицуулах Хорооны буруу гэж ойлголгүй харин манай компанийг хөрөнгөө босгож чаддаггүй гэсэн яриа гарч бидний нэр хүнд унасан нь манай компанийн ажилд ихээхэн саад болсоор байна.

Манай асуудлыг одоо ч шийдвэрлэж өгөхгүй байна. Өнгөрсөн онд асуудлаа шийдвэрлүүлэхээр Санхүүгийн Зохицуулах Хороонд албан бичиг өгсөн. Хариуд нь Үнэт цаасны газрын дарга Лхагвасүрэн нь өөрсдийн буруугаа хүлээн зөвшөөрч, манай асуудалд хайхрамжгүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцсон тухай албан бичгийг бидэнд ирүүлээд байна. Та бүхэний өмнө уг албан бичгийг тавьсан байгаа.

Хувьцаа эзэмшигч “Мезза Файнэншл Групп” ХХК түүнийг төлөөлж Камоллиддин Талипов:

Бүтэн жил өнгөрч байхад бас л ямар ч хариу байхгүй юу. Арай үгүйбайлгүй дээ. Ингэж ажиллаж байж Монгол улс гаднаас хөрөнгө оруулалт татаж, гадны хөрөнгө оруулагчдыг дэмжинэ гэж байгааг үнэхээр ойлгохгүй байна.

“Омега Инвест” ХХК компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Энэ асуудлыг шийдэхгүй удаж байгаад гүнээ харамсаж байна.

Хурлын дарга Г.Оюунболд:

Бидний хэлэлцэх дараагийн асуудал бол “Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах” байгаа. Энэ асуудлыг та бүхэнд “Евразиа капитал холдинг” ХК – ийн Гүйцэтгэх захирал, компанийн хувьцаа эзэмшигч Г.Оюунболд би танилцуулна. Та бүхэнд тарааж өгсөн төлөвлөгөөнд анхаарлаа хандуулна уу.

Та бүхэнд асууж тодруулах зүйл байвал санаа зоволтгүй асууж болно.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй.

ТУЗ-ийн дарга Г.Халиунаа:

- Ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн шийдвэрийг та бүхэн танилцуулж байна. Энэ компанийг өнгөрсөн хугацаанд ашиггүй ажиллуулах гол нөхцлийг бүрдүүлсэн зүйл бол татан төвлөрүүлэх байсан хөрөнгийг шийдэж өгөөгүй мөн нэр хүндийг унагасантай холбоотой гэж үзэж байна.
- манай хувьцаа эзэмшигч Г.Оюунболдын санал болгосноор “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-тай Люкс Занаду Групп ХК-г нэгтгэх асуудлыг та бүхэнд танилцуулж байна. Та бүхний урд “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн дэлгэрэнгүй танилцууллага болон, нэгтгэх төслийг тавьсан байгаа.
- **Хувьцаа эзэмшигчид:** Асуудлыг ойлголоо. Дэмжиж байна. Гэхдээ ТУЗ энэ асуудлыг хариуцан ажиллаж төслийг дахин сайжруулж төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аван ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Хурлын дарга Г.Оюунболд: Бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудалд багтсан бусад гэх асуудлын хүрээнд ТУЗ-ийн гишүүдийг сонгох байгаа. Танилцууллагатай танилцаад саналаа хэлээрэй.

Хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлтийн дараа саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

“Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна” хэмээн Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ж.Ганзориг танилцууллаа.

“Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн 2020 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. ТУЗ-өөс хуралд оруулж ирсэн компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дэмжин батлав.
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.
3. Компаний нэгтгэх саналыг зөвшөөрч ТУЗ-д бүрэн эрхийг шилжүүлэв.
4. Бусад асуудлын хүрээнд ТУЗ-ийн гишүүдийг сонгов.

Хурлын дарга Г.Оюунболд хурлыг хаав.

Хурал: 11 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

Хянасан:

Хурлын дарга:



У.Анар

Г.Оюунболд